



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/156

Номгон

Техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн
албан татвар хураалтын ажлыг зохион
байгуулах тухай

Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагааг жилийн турш холбогдох дүрэм, журам, стандартуудын шаардлагыг хангуулсны үндсэн дээр аймгийн Татварын хэлтэс, сумдын Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн тасаг, хэсэг, багийн Засаг дарга нартай хамтарч чанартай зохион байгуулахыг Автотээврийн төв (С.Амармөнх)-д үүрэг болгосугай.

2. 2023 оны тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн ажлыг зохион байгуулах аймгийн комиссыг нэгдүгээр, сумдад ажиллах комиссыг хоёрдугаар, үзлэгийн хуваарийг гуравдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

3. Тус аймгийн иргэд, байгууллагын эзэмшилд бүртгэлтэй байгаа автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, орон нутгийн автозам ашигласны төлбөр хураамжийг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хураан авч төсөвт бүрэн төвлөрүүлэхийг аймгийн Татварын хэлтэс (С.Рэнцэндагва)-т үүрэг болгосугай.

4. Сумынхаа албан байгууллага, иргэдийн болон нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн аж ахуйн нэгж, байгууллагын тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэг, албан татвар хураалтад бүрэн хамруулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

5. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан байдал, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, орон нутгийн автозам ашигласны төлбөр төлөлт, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хэрэгжилтэд бүтэн жилийн турш хяналт шалгалтыг тасралтгүй хийж, зөрчлийг тухай бүр арилгуулахыг

642310413

2.

Цагдаагийн газар цагдаагийн дэд хурандаа (Б.Мөнхбаяр), Автотээврийн төв (С.Амармөнх) нарт үүрэг болгосугай.

6.Техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн албан татвар хураалтыг орон нутагт зохион байгуулсан дүн мэдээг үндэслэн сумдын Засаг дарга нарын үр дүнгийн гэрээнд үнэлэлт дүгнэлт өгч ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэс (Л.Мандал)-т, ажлын үр дүнг улирал тутам танилцуулахыг Комиссын дарга (С.Амармөнх)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын ... оны ... дарын...-ны
өдрийн... дугаар захирамжийн 1 дүгээр
хавсралт




ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ АЙМГИЙН
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

- С. Амармөнх -Автотээврийн төвийн дарга
- А.Батхуяг-Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга
- Т.Энхмандах – Аймгийн Татварын хэлтсийн Орлогын тасгийн дарга
- Д.Магвансүрэн- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн Зам тээврийн хяналтын улсын ахлах байцаагч
- Б.Базарсад -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, Хөрөнгө оруулалтын хэлтсийн Зам, тээврийн асуудал хариуцсан мэргэжилтэн

_____оОо_____

Аймгийн Засаг даргын _____ оны _____ сарын 27-ны
өдрийн 1136 дугаар захирамжийн 2 дугаар
хавсралт



**ТЕХНИКИЙН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ САЛБАР
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Сумдад ажиллах комисс:

Д.Баттулга - Автотээврийн төвийн Техникийн хяналтын үзлэгийн инженер

Б.Ганболд-Автотээврийн төвийн Бүртгэлийн мэргэжилтэн

Ч.Балжинням-Автотээврийн төвийн Техникийн хяналтын үзлэгийн техникч

Сумын Засаг даргын Захирамжаар томилогдсон салбар комисс /Татварын
улсын байцаагч, сум дундын Цагдаагийн тасгийн дарга, сумын Цагдаагийн хэсгийн
төлөөлөгч, цагдаа, багийн Засаг дарга нар/

_____ оОо _____

Аймгийн Засаг даргын _____-ны _____ сарын _____-ны
 өдрийн _____ дугаар захирамжийн 3 дугаар



20

ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ
 ХУВААРЬ

№	Сум, багийн нэр	Хоног	Хугацаа
1	Баянхонгор аймгийн төв		01 дүгээр сарын 02-ноос 4 дүгээр сарын 21
Говийн чиглэл			
2	Жинст	2	4 дүгээр сарын 24-нөөс 04 дүгээр сарын 25
3	Богд	2	4 дүгээр сарын 26-наас 04 дүгээр сарын 27
4	Баянлиг	3	4 дүгээр сарын 28-наас 04 дүгээр сарын 30
5	Баянговь	3	5 дугаар сарын 01-нээс 05 дугаар сарын 03
6	Шинэжинст	2	5 дугаар сарын 04-нөөс 05 дугаар сарын 05
7	Баян-Өндөр	2	5 дугаар сарын 06-наас 05 дугаар сарын 07
8	Баянцагаан	3	5 дугаар сарын 08-наас 05 дугаар сарын 10
9	Баацагаан	2	5 дугаар сарын 11-нээс 05 дугаар сарын 12
10	Баянхонгор аймгийн төв		5 дугаар сарын 15-наас 05 дугаар сарын 19
Хангайн чиглэл			
11	Бөмбөгөр	2	5 дугаар сарын 22-ноос 5 дугаар сарын 23
12	Бууцагаан	3	5 дугаар сарын 24-нөөс 5 дугаар сарын 26
13	Хүрээмарал	2	5 дугаар сарын 27-ноос 5 дугаар сарын 28
14	Баянбулаг	2	5 дугаар сарын 29-нөөс 5 дугаар сарын 30
15	Гурванбулаг	2	5 дугаар сарын 31-нээс 6 дугаар сарын 01
16	Заг	2	6 дугаар сарын 02-ноос 6 дугаар сарын 03
17	Жаргалант	2	6 дугаар сарын 04-нөөс 6 дугаар сарын 05
18	Галуут	2	6 дугаар сарын 06-наас 6 дугаар сарын 07
19	Баян-Овоо	1	6 дугаар сарын 08
20	Эрдэнэцогт	2	6 дугаар сарын 09-нөөс 6 дугаар сарын 10
21	Өлзийт	2	6 дугаар сарын 12-ноос 06 дугаар сарын 13
22	Шаргалжуут /Баянхонгор сум/	1	6 дугаар сарын 14
23	Уул уурхайн байгууллага	3	6 дугаар сарын 21-нээс 6 дугаар сарын 23
24	Сумдад ажиллах хоног	45	
25	Баянхонгор сум		6 дугаар сарын 15-наас 12 дугаар сарын 28